



**ЗАВХАН АЙМГИЙН  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА  
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 09

Улиастай

┌ ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН ┐  
ТАЙЛАН

Албаны 2022 оны дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Албаны даргын баталсан 10 дугаар удирдамжаар Улиастай сумын ЗДТГ-ын 2020, 2021 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс ДА-СХШУБ Б.Батхүү ахлан, ДА Б.Үүрийнтуяа нар дотоод аудит хийж гүйцэтгэв.

Хөрөнгө оруулалт, томоохон хийгдсэн ажлууд

2020 оны 02 сард цагаан сарын баярыг тохиолдуулан багуудын 172, байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад хүндэтгэл үзүүлж 4000,0 мянган төгрөгийг тараасан.

2020 оны 03 сард “Завхан харуул” ХХК-тай “Шар усны үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд товцогийн хар үзүүр орчим богдын голын салааны уулзварын голдиргыг өөрчлөх” 5000,0 мянган төгрөгийн ажлын гэрээ байгуулсан. Гэрээнд ажлын хөлсийг тусгаагүй

2020 оны 03 сарын 17-ны өдөр Жаргалант эх булаг ХХК-аас 3500,0 мянган төгрөгөөр сэлбэг худалдан авсан

2020 оны 05 сарын 22-ны өдөр Си Ти Эс компаниас 1650,0 мянган төгрөгөөр санхүүгийн программ худалдан авсан /ашигладаггүй/.

Жаргалант багийн ажлын алба Цагдаагийн газрын байцаагчтай хамтран иргэдэд сургалт, сурталчилгаа, мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулж 1000,0 мянган төгрөгөөр 101 хүнд дэвтэр, бал, маск, ариутгагч тараасан

УСЗДТГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны тайлангийн сэтгүүлийг 2020 оны 09 сард Мөнх-Ундрах ХХК-тай гэрээ байгуулан 4100 ширхэгийг 2085 төгрөгөөр нийт 8548,5 мянган төгрөгөөр хэвлүүлсэн

2020 оны 9 сард Малчдын зөвлөгөөн хийж 1000,0 мянган төгрөг зарцуулсан

Улиастай сумын 9-р цэцэрлэгийн барилга ашиглах боломжгүй болсонтой холбогдуулан хуучин барилгын буйр цэвэрлэж зөөх, нүхэн жорлон, муу усны суваг ухах, барих зэрэг ажлын 7880,0 мянган төгрөгөөр Оч дөл өлзийт ХХК гүйцэтгэсэн

НҮБ-ийн хөгжлийн сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилт Улиастай сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 10023,5, аймгийн ЗДТГ-аас нэмж 3945,0 мянган төгрөгийг хийж 3-12 дугаар ангийн 605 хүүхдэд саван, гар ариутгагч, нойтон сальфетка тараасан мөн гэр хорооллын айлуудын нүхэн жорлонг ариутгах ажлын хийсэн байна

2020 оны 5 сард 5569,0 камержуулалт үлдэгдлийг “Үзүүр цахирын хишиг” ХХК-руу шилжүүлсэн

2020 оны 06 сард “Цэн эко төсөл” ХХК-тай гэрээ байгуулан 15000,0 мянган төгрөгөөр “Өлзийт багт үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, дарж булах” ажлыг зохион байгуулсан /тендерт шалгарсан/

2020 оны 9 сард “Баянбалбар” ХХК-тай гэрээ байгуулан 75000,0 мянган төгрөгөөр Улиастай сумын 20 орон сууцны өнгөлгөөний ажлыг хийсэн /тендерт шалгарсан/

2020 оны 9 сард “Од оч тренд” ХХК-тай гэрээ байгуулан 19975,0 мянган төгрөгөөр Чигэстэй багийн гэрэлтүүлэгийн ажлыг хийсэн /тендерт шалгарсан/

Аймгийн Засаг даргын Захирамжаар ахмадын баярыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 8000,0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтын дансаар дамжуулан олгож цайны багц худалдан авч тараасан.

2020 оны 10 сард “Цэн эко төсөл” ХХК-тай гэрээ байгуулан 30000,0 мянган төгрөгөөр Жинст, Богдын гол, Чигэстэй, Жаргалант, Өлзийт, Товцог багуудын гэр хорооллын гудамжны шороон замыг шороо асгаж тэгшлэх, хусаж сайжруулах ажлыг зохион байгуулсан /тендерт шалгарсан/

2020 оны 10 сард “Арга нэмэх инженеринг” ХХК-тай гэрээ байгуулан 10000,0 мянган төгрөгөөр Улиастай сумын хатуу хучилттай авто зам засварлах ажлыг зохион байгуулсан /тендерт шалгарсан/

2020 оны 12 сард “Үзүүр цахирын хишиг” ХХК-тай гэрээ байгуулан 6990,0 мянган төгрөгөөр Улиастай сумын замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах ажил зохион байгуулсан байна.

#### Засаг даргын нөөц сангийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын талаар

Сумын ИТХ-аар 2020 онд зарцуулах засаг даргын нөөц сангийн хөрөнгийн төсвийг 41500.0 мянган төгрөгөөр , 2021 онд зарцуулах засаг даргын нөөц хөрөнгийн төсвийг 41500.0 мянган төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 2020 онд 32160.0 мянган төгрөг, 2021 онд 80662.4 мянган төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 2020 онд 9340.0 мянган төгрөгөөр хэмнэж , 2021 онд 39162.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. / 2020, 2021 оны гүйцэтгэлийг хүснэгтээр, дэлгэрэнгүй гаргаж хавсаргав./

#### Нэмэлт санхүүжилт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, төсөл хөтөлбөрийн үр дүн

Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжин зарцуулагдаж байгаа хандив, хураагдсан бараа, эд зүйлийн орлого, өвсний үнэ, автобусны орлого зэрэг нь байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдаж төсөв хэтрэх нэг шалтгаан болж байна. Мөн ОНХС-аас зарим тендертэй холбоотой ААНБ-тай хийсэн гэрээний санхүүжилтийг дамжуулан ажил үүргээ гүйцэтгээгүй байгууллагын санхүүжилтыг 100% олгосон зөрчил байна. Жишээлбэл: Таван тайхар ХХК-д Товцог багийн гүүрний санхүүжилт 20,0 сая төгрөг, гэрээний хугацаа 2022.04.01-нд дууссан. Жаргалант их булаг ХХК-д Нийтийн эзэмшлийн гудамж талбайд давс, бодис цацах ажлын санхүүжилт 20.0 сая төгрөг, гэрээний хугацаа 2022.03.01-нд дууссан. Улиастай сумд 2020-2021 онд хэрэгжсэн ХЭЭГБХ төслийн санхүүжилтаар 2020.11.20-нд 5954.1 мянган төгрөг, 2021.08.18-нд 6168.7 мянган төгрөг нийт 12122.8 мянган төгрөг орж ирснийг тавилга, тоног төхөөрөмж, аж ахуйн болон бичиг хэргийн материал, утасны нэгж, интернетийн төлбөр, сургалтын болон ажлын хөлс зэрэгт зарцуулсан байна /Зарцуулалтыг хүснэгтээр гаргаж хавсаргав/

#### **АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, АУДИТЫН ҮР ДҮН**

Аудитаар илэрсэн зөрчил:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол, “Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс

хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам”, Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн №1/48/88 тоот тушаал “Цалингийн нэмэгдлийг санхүүжүүлэх” тухай тушаалтай холбоотой зөрчил, дутагдал гарч байна.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслийг худалдан борлуулаад орлогыг төсвийн орлого болголгүй өөрийн нэмэлт санхүүжилтийн дансанд тушаан үйл ажиллагаандаа зарцуулсан. Энэ нь Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2 “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого” заалтыг зөрчсөн

Ажилчдын цалингаас суутгасан ХХОАТ-ын өглөг, авлагын зөрүүг данс бүртгэлд тусгаагүй ба 2020 онд дутуу, 2021 онд илүү төлөлттэй

Засаг даргын захирамж, тамгын газрын даргын тушаалуудын дугаар алгасах, давхцах асуудал байна. Зарим аж ахуй нэгж, хувь хүмүүстэй байгуулсан гэрээний биелэлтийг тооцоогүй, гарын үсэг, тамга тэмдэг дутуу

Ажилчдад томилолтын зардал хүчин төгөлдөр бус томилолтын хуудсаар олгосон

Жолооч нарын тооцоог сар бүр бодож үлдэгдлийг баталгаажуулдаггүй

Аж ахуйн няравын тайланг цаг тухай бүр нь гаргуулж авдаггүй

Ажилчдад амралтын мөнгө болон цалин илүү олгосон

Сумын ИТХ-ын хоолны зардлыг тамгын газраас төлсөн

Санхүү албаны дарга Ж.Лхагважавт дотоод аудитын нэмэгдэл олгосон

Сумын засаг дарга Ч.Наранбатын 2020.12.18-ны өдрийн №Б/30 тоот захирамжаар засаг даргын орлогч Ч.Батсүхэд статистикийн нэмэгдлийг ажил хавсарсны нэмэгдэл гэж 40%-аар олгосон

Дээрх зөрчлүүдтэй холбоотой нийт 6822,6 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэлээ.

## НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дотоод аудитаар танай байгууллагад доорх зөвлөмжийг өгч байна.

Засгийн газрын 2019 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн “Дотоод аудитын нэгж” байгуулах

Дотоод хяналтын нэгж ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, тоног төхөөрөмжийн эвдрэл, сан техникийн засвар хийх г.м ажлуудад акт үйлдэж шалтгаан нөхцөлийг тогтоодог болох

Бараа материал худалдан авахдаа и-баримтанд тоо хэмжээ, нэр төрөл бүрийн үнийг тодорхой бичүүлэх дэлгэрэнгүй хэвлүүлэх

Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг тухай бүр авч, зардлыг гаргах /харилцагч байгууллага, иргэн НӨАТ-ын баримт олгоогүй, шивээгүй тохиолдолд харьяа татварын албанд мэдэгдэж арга хэмжээ авч байх/

Ажиллагсдын цалингаас суутгасан НДШ, ХХОАТ, ҮЭ-ийг тухай бүр шилжүүлэх, өглөг авлага үүсгэхгүй байх

Сар бүр НДШ-ийн тайланг, улирал бүр ХХОАТ-ын тайланг тус газруудын холбогдох мэргэжилтэнтэй тооцоо нийлж баталгаажуулдаг байх

Байгууллагын данс бүртгэлд туссан авто машинд шатахуун хийж албан ажилд шатахуун зарцуулах, мэргэжилтнүүдэд шатахуун олгохдоо хийсэн ажлын тайлан бичүүлж, шатахууны зарцуулалтын тооцоог хийж илүү, дутууг тооцож байх, замын хуудсыг стандартын дагуу бодитой бичүүлэх /БОХ-ын байцаагчийн эргүүл хяналт хийх хуваарийг нарийвчлан гаргаж шатахууны үрэлгэн зарцуулалтыг зогсоох!!!!/

ААНэгж, хувь хүнээс бараа ажил үйлчилгээ авахдаа Гэрээ байгуулан зардлыг гаргаж хэвших

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын дагуу төсвийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулах

Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 04 дүгээр сарын 5-ны өдрийн № 1/48/88 тоот тушаалыг хэрэгжүүлэх

Нөхөн төлбөрийн актыг хугацаандаа барагдуулах

Тайлан бэлтгэсэн:

Санхүүгийн хяналт аудитын албаны  
ДА-СХШУАБ Б.Батхүү  
ДА Б.Үүрийнтуяа

